



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 116

Амардалай

Сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагааг
түр зогсоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1.4, Боловсролын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.1, сумын Онцгой комиссын 2022 оны 01 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хэмжээнд бага насны хүүхдүүдийн дунд томуу, томуу төст өвчний дэгдэлт нэмэгдэж байгаатай холбогдуулан болзошгүй эрсдэлүүдээс урьдчилан сэргийлэх зорилгоор сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үйл ажиллагааг 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдрөөс 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг дуустал түр хугацаагаар зогсоосугай.

2. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын үйл ажиллагааг түр зогсоох хугацаанд сургалтын хөтөлбөрийн дагуу цахим сургалтыг зохион байгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч (Х.Эрдэнэтуяа)-д, бага насны хүүхдээ болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, асарч хамгаалах, цахим сургалтыг хүргэх, мэдээлэл арга зүйгээр хангаж хамтран ажиллахыг нийт эцэг эх, асран хамгаалагчдад даалгасугай.

3. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байгаа бага насны хүүхэдтэй албан хаагчид үр хүүхдийнхээ аюулгүй байдлыг ханган, асран хамгаалагчтай үлдээж хариуцлагатай ажиллахыг нийт төрийн албан хаагчдад үүрэг болгосугай.

4. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын үйл ажиллагааг тус хугацаанд хэвээр үргэлжлүүлж, томуу томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчлөлийн талаарх мэдээллийг өдөр бүр авч, нөхцөл байдалд дүгнэлт хийн, сургалтын хоцрогдолтыг арилгахад шуурхай арга хэмжээ авч ажиллахыг Ерөнхий боловсролын сургуулийн Захирал (А.Мөнхбаатар)-т захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Л.Золжаргал) нарт үүрэг болгосугай.



ДАРГА

М.БАЯРСҮХ

4880200513